



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 06 өдөр

Дугаар 4/489

Номгон

Г Автомашин, тоног төхөөрөмж хүлээж авах
ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2."а, г" заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газарт дуудлага үйлчилгээний автомашин, тусгай зориулалтын 5тн багтаамж бүхий усны савтай, шүршигч машин 4 ширхэг, явуулын тусгай зориулалтын лабораторийг хүлээж авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Т.Хишигбаатар – Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг орлон гүйцэтгэгч

Гишүүд: Б.Биндэръяа –Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Оюун-Эрдэнэ – Мал эмнэлгийн газрын дарга

Б.Баярмаа – Мал эмнэлгийн газрын Лабораторийн эрхлэгч

Ж.Өлзийжаргал – ЗООНОЗ халдварт өвчин судлалын тандалтын асуудал хариуцсан мэргэжилтэн


Нарийн бичгийн дарга: Г.Баатарцогт- Орон нутгийн өмчийн газрын Өмчийн асуудал хариуцсан мэргэжилтэн

2.Тээврийн хэрэгслийг 2020 оны 8 дугаар сарын 10 -ны өдрийн дотор хүлээн авч байгууллагын өмчид бүртгэж авахыг нарийн бичгийн дарга (Г.Баатарцогт)-д үүрэг болгосугай.

3.Мал эмнэлгийн дуудлага үйлчилгээний автомашин, шүршигч машин, явуулын лабораторийг техникийн тодорхойлолттой тулган хүлээн авч ажлын тайланг 8 дугаар сарын 15-ны дотор танилцуулахыг ажлын хэсэг / Т.Хишигбаатар /-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг орлон гүйцэтгэгч (Д.Өнхжаргал)-д даалгасугай.

ДАРГА



ДИМӨНХСАЙХАН

601210127